

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дугар	Дугаар	L300
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Цэцэрлэг сум
Төрсөн газар	Цэцэрлэг сум	Төрсөн он	1919
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тэсийн хүрээ, Шаварын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨЦЦ 027, ХӨЦЦ 028
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Тэсийн хүрээ, Шаварын хүрээ

Мөнхбат: Тэгэхээр Дүүрэгч вангийн хошууны хүрээ буюу Тэсийн хүрээ тухайн цаг үедээ ямар ямар хурал хурдаг, хэдэн дуган дацантай байсан юм бол?

Дугар: Нэлээн олон, за нэг хорин зургаан дацантай байсан юм даг.Тэгээд л тэр маань тэгээд л сүүлдээ байхгүй болсон.

Мөнхбат: Цам гаргах, майдар эргэх зэрэг шашин номын ямар үйл ажиллагаа явуулдаг байсан бол?

Дугар: Цам, цам гэж байсан юм. Майдар гэж байсан юм.Тэр ямар, ер нь дутуу юм ер байхгүй байсан байна шүү.Овоо ч хүрээ байсан юм, уг нь. Зургаан аймагтай хүрээ байсан юм.

Мөнхбат: Энэ хүрээний гол одоо шүтээн, сахиус?

Дугар: Гол шүтээн Сэндэм гэж байсан юм.

Мөнхбат: Сэндэм?

Дугар: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Одоо өнөөдөр энэ Дашлин хийдийн залгамжлаад л ингээд шүтээн тавьж байгаа юм байна ш дээ, тийм ээ?

Дугар: Тийм.Сэндэм гэдэг шүтээнтэй байсан юм.

Мөнхбат:Тэгэхээр одоо ер нь тухайн үедээ Тэсийн хүрээний жасын гол, жас нь одоо хэдий хэмжээний жастай байсан юм, энэ талаар одоо таны...?

Дугар: За мэдэхгүй ээ, тэр чинь одоо ер нь нарийн дээрээ за мэдэхгүй ээ, мэдэхгүй. Уг нь миний мэддэг юу болохлээр Тэсийн хүрээ л гэж байдаг байсан юм. Дүүрэгч вангийн хошууны хүрээ л гэж байсан юм.Тэрнээс хойшоогоо болохлээр зэрэг багассаар байгаад л байхгүй болсон.Түүнээс биш тэгээд нэмэгдэж байсан юм аа, уг нь чиг.

Мөнхбат: Ном сударт нэг яг шашин номынхоо ид хөгжлийн үед хоёр мянгаад ламтай байсан гэж тэмдэглэгдсэн байдаг юм .Энэ одоо ер нь хэр бодитой тоо бол?

Дугар: За ер нь хоёр мянгаадыг нь хэн мэдэхэв. За лав мянгаад хувраг ч байсан. Олон хуврагтай байсан юм даг.

Мөнхбат: Энэ Тэсийн хүрээний хувь заяа 1937, 1938 оны үед монголын буддын шашны хүрээ хийдийг дайрч гарсан тэр гашуун хар өдөр жилүүд бол бас тэр хүрээг бол дайрч гарсан нь ойлгомжтой , тийм ээ? Тэгэхээр хүрээг яг одоо гучин долоо, гучин найман оны үед лам нарыг нь хар болгочихоод, шууд хүрээг одоо устгаж байсан юм болов уу, эсвэл урьдчилж одоо лам нарыг хөдөө гаргаж энгийн болгочихоод, хар болгочихоод дараа нь энэ хүрээний сүм дуган үлдэж байсан юм болов уу, лам нартайгаа зэрэг байхгүй болсон юм болов уу?

Дугар: За энэ чинь уг нь урдаар нөгөө лам нар маань юу яасан юм даа, гаргачихсан юм даа, тараачихсан.Томхон томхонуудыг нь барьж, бариад яваад байхаар бага хоцорсонгууд нь учраа мэдэхгүй тараад л тэгээд зогссон юм даа.

Мөнхбат: За тэгвэл Дүүрэгч вангийн хошууны шашин номын томоохон төв байсан...?

Дугар: Дүүрэгч вангийн хошуу гэж байсан юм.

Мөнхбат:Тийм, энэ Тэсийн хүрээний талаар танаас энэ удаагийн мэдээллийг авлаа.Ингээд танаас дараа нь асуух ю м, энэ Цэцэрлэг сумын нутаг дээр хамгийн хойд улсын хилд ойрхон байсан, тэр Шаврын хүрээ?

Дугар: Аа тийм.

Мөнхбат: Тийм, энэ хүрээний талаар одоо та товч мэдээлэл өгөөч?

Дугар: Бага хүрээ байсан юм аа. Жаахаан бага нэг гуравхан дугантай, тийм хүрээ байсан юм, уг нь.Тэрэндээ яахав хурдаг хурлуудаа хурж л байсан, цаг цагийнхаа хурлуудыг.Тийм байсан, хурал нь ч гэсэн тогтмол байдаггүй байсан юм аа. Тийм л байсан юм даг.

Мөнхбат: Бас л Тэсийн хүрээтэйгээ адилхан тэр цаг үед мөхсөн үү, тийм ээ?

Дугар: Тийм, Тэсийн хүрээн дээр чинь одоо чойр , мамба гээд олон янзын юм байдаг. Тэр Шаврын хүрээн дээр чинь чойр, мамба гэсэн юм байхгүй.Зүгээр л гурван дуган байж байдаг, тэрэн дээрээ зүгээр жирийн хурлуудаа хураад л байж байдаг. Тийм л байсан юм.Тэсийн хүрээ чинь их хүрээ байсан юм. Дацан олонтой байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Тэгэхээр бид нар бас нэг ийм мэдээлэл сонссон л доо.Энэ Шаврын дуганы гурван дуганыг бүр одоо дөч тавиад оны үед байж байсан.

Дугар: За тэгсэн.

Мөнхбат: Жараад оны үед бол энэ Цэцэрлэг сум нэгдэл гэж байх үед нэгдлийн ферм түлээнд хураагдсан гэж тэр одоо үнэн мэдээлэл үү?

Дугар: Ээ тийм үнэн байх учиртай. Байхгүй д болчихсон юм даг.Түлээнд хураагдсан байх аа, ачаад байсан юм.

Мөнхбат: За таньд их баярлалаа.Монголын буддын шашны түүхэн хөгжилд, монголын хүрээ хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны багт үнэтэй мэдээлэл өгсөн таньд их баярлалаа.Та урт удаан наслаарай.

Дугар: За тэгэхээр та нар одоо уг нь юу яах гэж санаатай байгаа юм, арилчихсан, байхгүй болсон байгаа юм, юмнууд нь, энэ Тэсийн хүрээний., чойр гэж байсан, мамба гэж байсан, жүд гэж байсан, дүйнхор гэж байсан, чог гэж байсан энэ чинь олон дацантай байсан юм аа.Ер нь энэ хавийн юу нь ер ын барагтай юманд ер нь их тийм юу яахгүйгээр байсан юм даа.Хуваргууд нь ч бас зөндөө байсан юм.

Мөнхбат: Эрдэмтэй чадалтай лам нар бас зөндөө байсан биз?

Дугар: Байлгүй яахав, байлгүй яахав.Олон байсан юм.Лут улсууд байсан юм.

Мөнхбат: Хамгийн сүүлчийн хамба нь хэн байсан юм, ямар хүн байсан юм бол? Тэсийн хүрээний хамгийн сүүлийн хамба?

Дугар: Хамгийн сүүлчийн хамба чинь Чойжинжав гуай гэдэг хамбаар л шувтарчихсан шиг байна лээ л дээ.

Мөнхбат :Тэр хүний удам угсаа гэж одоо бас өнөөдөр Цэцэрлэг суманд амьдарч байгаа хүмүүс байгаа даа ?

Дугар: Үгүй ер нь мэдэхгүй. Уг нь байхгүй байж мэднэ шүү.

Мөнхбат :Тийм, бас л одоо нэг сахилаа сахисан тийм гэр бүлгүй хүн байсан байж таарна, тийм ээ?

Дугар: Ер нь уг нь тэр чинь их цэвэрч хүн байсан юм шүү. Тэгээд л хүрээн дээр л байж байгаад өнгөрчихсөн дөө. Түүнээс биш тэр шавь нар нь байсан гэхээс ах дүү гээд нэг их тийм юу яагаад байсныг нь мэдэхгүй ээ, тэр шавь нартай л байсан юм. Шавь нар нь л гадуур нь байдаг байсан юм.

Мөнхбат : Тэр хэлмэгдүүлэлтийн, тэр лам нарыг баривчилж аваад хэлмэгдүүлж байсан жилүүдэд Тэсийн хүрээнээс яваад алга болсон бүр одоо тийм хэлсээр гэх юм уу, дээд хэмжээ авсан тийм лам хуваргууд бас цөөнгүй байсан биз?

Дугар: Уг нь байж л байсан юм.Тэгээд л тэр томхон шигүүдыг нь ийшээ л аваад яваад байсан. Тэгээд хаагдсан хэрэг.

Мөнхбат :Эргэж ирээгүй?

Дугар: Эргэж ирээгүй. Ер нь юм ирээгүй.

Мөнхбат: За баярлалаа, танд.

Дугар: Тийм, тэгээд л болж байгаа нь тэр.